



БУЛГАН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# БУЛГАН АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН байдал

Monthly bulletin of **STATISTICS**

2019/4  
[www.bulgan.nso.mn](http://www.bulgan.nso.mn)



# СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?

**www.1212.mn**  
СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН  
НЭГДСЭН САН

www.nso.mn сайтын  
Хэрэглэгчийн бүртгэлд  
бүртгүүлснээр цахим  
хаягаар тогтмол  
авч болно.

Monstat ezStat  
аппликейшн

1900-1212  
Лавлах утас

@statistic\_mn

Статистик  
мэдээлэл

Үндэсний Статистикийн  
Хорооны  
НОМЫН САН

Онлайн лавлах  
мессенжер  
8:30-17:30

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ

ХҮНД СУРТАЛ  
АВИЛГА

ҮГҮЙ НЭЭЛТТЭЙ  
ХҮРГЭНЭ

**ГАРЧИГ**

Аргачлалын тайлбар.....	2
Товч танилцуулга.....	6
I. 1 Хүн ам.....	14
I. 2 Хөдөлмөр.....	15
I. 3 Нийгмийн халамж.....	16
I. 3 Нийгмийн даатгал.....	16
I. 4 Эрүүл мэнд .....	17
I. 6 Гэмт хэрэг .....	18
II.2 Банк, Санхүү.....	19
II.3 Үнэ.....	20
II.6 Аж үйлдвэр.....	25
II.6 Барилга.....	26
II.8 Худалдан авах ажиллагаа.....	27
II.9 Газар өмчлөл.....	32
II.10 Бизнес регистрийн сан.....	32
II.14 Мал аж ахуй.....	34
II.15 Газар тариалан.....	38

## Аргачлалын тайлбар

### Хөдөлмөр

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхлэгдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

### Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулах, өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ. Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн

даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно. Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ

### Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн

хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана. Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиодлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

### **Аюулт үзэгдэл, осол**

Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Аюулт үзэгдэл гэж хүчтэй цасан болон шроон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг хамруулан ойлгоно. Техникийн холбогдолтой осол гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга, байгууламж, шугам, сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох,

сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг хамруулан ойлгоно.

### **Гэмт хэрэг**

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн шинж чанар, аюулын хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна. Гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна. Тухайлбал:

- Хүний ам бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Хүүхэд гэр бүл, нийгмийн эсрэг гэмт хэрэг
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг
- Бусад гэмт хэрэг

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог тодорхойлохдоо нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18 ба түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулна.

Дор дурьдсан этгээдэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэж, үндэслэл бүхий тогтоол гаргасан бол сэжигтнээр тооцно. Үүнд:

-Уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдэл дор нь барьсан

-Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан

-Уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон

-Уг этгээд хэргээ илчлэн ирсэн

-Гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонгосон этгээдийг яллагдагчаар тооцно.

### **Төрийн санхүү**

Орон нутгийн төсвийн суурь орлого гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг хэлнэ. Орон нутгийн суурь зарлага гэж сум, аймаг, нийслэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлага, нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг хэлнэ.

Төсвийн тэнцэл гэж тухайн төсвийн жил, улирлын нийт орлого, зарлагын зөрүүг хэлнэ. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж зарцуулах төсөв нь орон нутгийн төсөв байна.

Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар орно.

Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны

ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, түрээсийн орлого, төсөвт газрын өөрийн орлого болон татварын бус бусад орлогоос татварын бус орлого бүрдэнэ.

Төсвийн зарлагыг урсгал зардал, хөрөнгийн зардал, цэвэр зээл гэж ангилна. Бараа, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс урсгал зардал бүрдэнэ.

### **Үнэ**

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна. ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглана. Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг. Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм. ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж болно.

$$I_p^L = \frac{\sum_{i=1}^n p_{it} * q_{io}}{\sum_{i=1}^n p_{io} * q_{io}}$$

$I_p^L$  - t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t - тайлан үе

o - суурь үе

$p_{it}$  - 'i' барааны тайлант үеийн үнэ,

$p_{io}$  - 'i' барааны суурь үеийн үнэ,

$q_{io}$  - 'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

$\sum$  - нийлбэрийн тэмдэг

### Ерөнхий тэмдэглэл

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв (I, II, III, IV, V... гэх мэт)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-X зэргээр илэрхийлэв.

II. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... мэдээлэл байхгүй

0.0 маш бага тоо

- гүйцэтгэл байхгүй

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

### Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар нь ангилахдаа НҮБаас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Хүн ам

Иргэний бүртгэлд шинээр төрсөн 105 хүүхэд, нас барсан 38 хүний бүртгэлийг бүртгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс шинэ төрсөн хүүхэд 308 буюу 3.8 дахин буурсан бол нас барал 86 буюу 3.2 дахин өсжээ.

Зураг I.1.2


Бүртгэгдсэн төрөлт, нас баралт



4-р сарын байдлаар 287 хүн шилжин ирж, 294 хүн шилжин явсан нь өмнөх оны мөн үеийнхээс шилжин ирсэн хүн 72 буюу 20 хувиар, шилжин явсан хүн 106 буюу 26.5 хувиар тус тус буурсан байна.

Зураг I.1.3

Бүртгэгдсэн шилжих хөдөлгөөн




I.2 Бүртгэлтэй, ажилгүй иргэн

Аймгийн хөдөлмөрийн хэлтэст ажил хайгч иргэн 1018 болсны 501 нь эмэгтэй байна. Ажил хайгч иргэдийн 0.1 магистр, докторын, 13.9 хувийг бакалаврын болон дипломын боловсролтой, 2.9 хувийг тусгай мэргэжлийн дунд, 4.6 хувийг техникийн болон мэргэжлийн, 64.6 хувийг бүрэн дунд боловсролтой, 9.8 хувийг суурь боловсролтой, 2.9 хувийг бага боловсролтой, 1.1 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.

Зураг I.2.1

Хөдөлмөрийн хэлтэст шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон иргэд



Аймгийн хэмжээнд ажил хайгч иргэдийн 14.5 хувийг 15-24 насны, 32.9 хувийг 25-34 насны, 27.5 хувийг 35-44 насны, 20.7 хувийг 45-54 насны, 3.7 хувийг 55-59 насны, 0.6 хувийг 60-аас дээш насны хүмүүс эзэлж байна.

**Зураг I.2.2**

Бүртгэлтэй ажилгүй иргэд боловсролын түвшингээр



**I.3.Нийгмийн даатгал, халамж**  
**Нийгмийн даатгал**

Нийгмийн даатгалын сангийн орлого 4263.9 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 938.4 сая төгрөг буюу 28.2 хувиар өсч, зарлага 19919.7 сая төг болж өмнөх оны мөн үеэс 8402.2 сая төг буюу 73.0 хувиар өссөн байна.

Тэтгэврийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 649(23.9%) сая төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 224.6(66.4%) сая төгрөгөөр, ажилгүйдлын даатгалын сангийн орлого 19.5(25.5%) сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага 19919.7 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс тэтгэврийн даатгалын сангийн зарлага 8373.6(76.9%) сая төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 45.5(11%) сая төгрөгөөр өсч, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 17.1(16.3%) сая төгрөгөөр, буурсан байна.

**Нийгмийн халамж**

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 32885 хүн 1533.6 сая төгрөгийн тэтгвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчид 349.3 сая.төг буюу 29.5 хувиар өсч, харин нийгмийн халамжийн тэтгэвэрт 995 хүн хамрагдаж 634.5 сая.төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 195.4 сая.төг буюу 44.5 хувиар өссөн байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтөд 29846 хүн хамрагдсаны 4 хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсан иргэд, 1.4 хувь ахмад настан, 40.6 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 54.0 хувь хүнс тэжээл хөтөлбөр хамрагдсан байна. Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлтөд 464.0 сая.төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 38.1 сая.төг буюу 8.9 хувиар өссөн байна.




**I.4 Эрүүл мэнд**

Аймгийн хэмжээнд 250 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 255 болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эх 15 буюу 6 хувиар, амьд төрсөн хүүхдийн тоо 13 буюу 5 хувиар тус тус буурсан байна.

**Зураг I.4.1**


Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд



Нялхасын эндэгдэл 7 гарсан нь 2 тохиолдол буюу 23 хувиар буурсан байна.

**Зураг I.4.2**

Зураг I.6.1



Халдварт өвчнөөр өвчлөгсөд 85 болж, өмнөх оны мөн үеийнхээс 139 тохиолдол буюу 17 хувиар өссөн байна. Нийт халдварт өвчнөөр өвчлөгсдийн 51 буюу 36 хувь нь амьсгалын замын халдварт өвчин, 68 буюу 48.9 хувь нь бэлэгсийн замын халдварт өвчнөөр өвчилсөн байна.

Зураг I.4.3

Халдварт өвчнөөр өвчлөгсөд



**Хэргийн өнгөөр нь авч үзвэл:**

- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 31 бүртгэгдэж 2 хэргээр буюу 6.8 хувиар
- Мал хулгайлах гэмт хэрэг 38 бүртгэгдэж 32 хэргээр буюу 5.3 дахин
- Залилах гэмт хэрэг 9 бүртгэгдэж 7 хэргээр буюу 3.5 дахин
- Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 3 бүртгэгдэж 3 хэргээр буюу 60 хувиар
- Хүнийг алах гэмт хэрэг 1 бүртгэгдэж 1 хэргээр буюу 100 хувиар өссөн байна.
- Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 9 бүртгэгдэн 5 хэргээр буюу 35.7 хувиар
- Хулгайлах гэмт хэрэг 22 бүртгэгдэж 3 хэргээр буюу 12 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

**Гэмт хэргийн улмаас учирсан хохирол**

Гэмт хэргийн улмаас нийт иргэд, аж ахуй нэгж байгууллагад 383.5 сая төгрөгний хохирол учирснаас иргэдэд 355.4 сая төгрөгний хохирол учирсан байна. Үүнээс бүртгэлд мөрдөн байцаалтын шатанд 179 сая төгрөг буюу 46.7 хувийн хохирлыг нөхөн төлүүлж ажилласан байна.



**I.6 Гэмт хэрэг**

Аймгийн хэмжээнд 152 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 63 хэргээр буюу 70.7 хувиар өссөн байна.

Зураг I.6.2

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол  
/сая.төг/

Гэмт хэргийн улмаас 16 хүн нас барсан ба өнгөрсөн оны мөн үеийнхээс 7 дахин өссөн байна. Бусдыг амиа хорлоход хүргэсэн гэмт хэргийн улмаас 11 хүн, ХАБТХАЖЭ гэмт хэргийн улмаас 4 хүн, хүнийг алах гэмт хэргийн улмаас 1 хүн амь насаа алдсан байна.

Хэргийн өнгөөр нь авч үзвэл: Гэмт хэргийн улмаас 36 хүн гэмтсэн нь ХЭМХБЭГХ-ийн улмаас 28, ХАБТХАЖЭ гэмт хэргийн улмаас 6, бусад хэргийн улмаас 2 хүн гэмтсэн байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 2.8 хувиар өссөн байна.


Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 18 бүртгэгдэж 9 хэргээр буюу 1 дахин өссөн.

Нийт 4 хэргийг бүлгээр үйлдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 8 хэргээр буюу 66.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

57 гэмт хэрэгт 81 хүн холбогдсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 32 хүнээр буюу 65.3 хувиар өссөн байна.

Зураг I.6.3

## Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан иргэн



## Захиргааны зөрчлийн талаар:

11335 зөрчилд 334.6 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна. Гудамж талбайд хэвийн бус явж орон гэртээ агсан согтуу тавьсны улмаас 298 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеийхээс 1.1 дахин өссөн байна. Захиргааны журмаар 77 хүнийг баривчилж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож эрхээ хасуулж, торгуулсан 79 иргэн байна.



## II. Эдийн засгийн үзүүлэлт

## II.1 Аймгийн төсөв

Аймгийн төсвийн нийт орлого 19019.3 сая төгрөг, зарлага 16945.7 сая төгрөг болж, аймгийн төсвийн нийт тэнцэл 2073.6 сая төгрөгний зэрэг гарлаа.

Зураг II.1.1


Аймгийн төсвийн орлого, зарлага, сая.төг



Орон нутгийн төсвийн орлогын 36.6 хувийг татварын орлого, 4.9 хувийг татварын бус орлого, 58.5 хувийг улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна. Төсвийн зарлага 2019 оны эхний 4-р сарын байдлаар 16945.7 сая.төг болоход 9262 хувийг бараа ажил үйлчилгээний зардал, 5.6 хувийг урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.

Зураг II.1.2

Аймгийн төсвийн өр, авлага сараар



Нийт өр 33.8 сая төгрөг байна. Үүнээс цалин, НДШ-ийн өглөг 7.3 сая, халаалт, гэрэл цахилгаан, түлш шатахууны өглөг 22.7 сая, албан томилолтын өр 3.0 сая, бусад зардлын өр 0.8 сая төгрөг байна. Нийт өрийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 56 сая. төгрөг буюу 62.4 хувиар буурсан байна.




### II.3 Үнэ Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеийнхээс 5.3 хувиар, оны эхнээс 2.5 хувиар, өмнөх сарынхаас 0.7 хувиар өссөн байна.

Зураг II.3.1

Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс, хувь, 2019 IV сар, (өмнөх сар =100%)



Хүснэгт II.3.1

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувиар,

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2019 IV 2018 IV	2019 IV 2018 XII	2019 IV 2019 III
<b>Ерөнхий индекс</b>	<b>100.0</b>	<b>105.3</b>	<b>102.5</b>	<b>100.7</b>
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	105.8	108.6	101.8
Согтууруулах ундаа, тамхи	3.2	100.5	101.7	100.2
Хувцас, бөс, бараа, гутал	16.1	103.8	101.2	100.2
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	103.5	100.1	100.1
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	102.6	100.3	100.1
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	3.6	115.3	101.6	100.7
Тээвэр	12.2	108.4	99.6	100.8
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	102.3	100.0	100.0
Амралт, чөлөөлт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	126.1	101.6	100.8
Боловсролын үйлчилгээ	4.7	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	107.3	107.2	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	99.8	100.9	100.9

## II.4 Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар ноолуур 102.2 мян.төгрөг, адууны дэл 4.4 мян.төгрөг, адууны сүүл 6.5 мян.төгрөг болсон бол үхрийн шир, адууны шир, хонины нэхий зах зээлд нийлүүлэлт байхгүй болсон байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулвал ноолуур 6.5 хувиар өссөн байна.

## II.5 Малын дундаж үнэ

Малын дундаж үнэ: Тэмээ 833.0 мян.төг, адуу 1027.0 мян.төг, үхэр 1068.0 мян.төг, хонь 154.0 мян.төг, ямаа 107.0 мян.төг болж буюу өмнөх оны мөн үетэй харьцуулвал тэмээ 12.2 хувиар буурсан бол адуу 41.5 хувиар, үхэр 48.7 хувиар, хонь 49.8 хувиар, ямаа 36.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.




## II.6 Аж үйлдвэр

Аймгийн аж үйлдвэрийн газрууд 1736.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 3138.3 сая төгрөгийн бүтээгдэхүүний борлуулалт нийсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 5.4 хувиар буурч, борлуулалт 5.3 хувиар өссөн байна. Өмнөх оноос үйлдвэрлэлт буурсан шалтгаан нь 2018 оны 9 сараас Орхон Мандал ХХК, Хангайн гурил ХХК, Интосэ ХХК нь буудай байхгүй гурлын үйлдвэрлэлт зогссон, 10 сараас хойш “Илчит металл” ХХК нь нуралт үүсч нүүрс олборлох боломжгүй үйлдвэрлэлт зогссонтой холбоотой байна.

Зураг II.6.1

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт, борлуулалт /сая.төг/



## II.14 Хөдөө аж ахуй Мал төллөлт, төл бойжилт

Аймгийн хэмжээнд 2018 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 1576.7 мянган хээлтэгч малын 1056.4 мянга буюу 67 хувь нь төллөсөн байна. Эм ямааны 70.8 хувь, эм хонины 74.3 хувь, ингэний 24.4 хувь, үнээний 30.4 хувь, гүүний 19.1 хувь төллөжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулвал мал төллөлт 18.4 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Гарсан төлийн 99.1 хувь буюу 1047.4 мянган төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулвал 1.3 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

## Зүй бусын хорогдол

Том малын зүй бусын хорогдол 10.9 мян.толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 66.6 мян.толгой мал буюу 86.8 хувиар буурсан байна. Нийт хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 818 толгой буюу 0.31 хувь, үхэр 884 толгой буюу 0.31 хувь, хонь 4960 толгой буюу 0.28 хувь, ямаа 4330 толгой буюу 0.42 хувь нь оны эхний малаас тус тус хорогдоод байна. Нийт хорогдлын адуу 6.7 хувь, үхэр 8.2 хувь, ямаа 41.2 хувь, хонь 43.8 хувийг тус тус эзэлж байна.

Хорогдлыг сумаар авч үзвэл Баян-агт сум 35.8 хувийг, Сайхан сум 17.0 хувь, Хутаг-Өндөр сум 12.1 хувийг тус тус эзэлж байгаа нь дийлэнх болж байна.


**Зураг II.14.1**

Зүй бусаар хорогдсон том мал, сумаар,



**Зураг II.14.2**

Том малын зүй бус хорогдол






### II.15 2019 оны 5 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээ

Бүс нутаг	I-р 10 хоног			II-р 10 хоног			III-р 10 хоног		
	Эхэн	Дунд	Эцэс	Эхэн	Дунд	Эцэс	Эхэн	Дунд	Эцэс
<p><b>Агаарын температур:</b> Энэ сарын агаарын дундаж температур нь 9-14 градус дулаан буюу нийт нутгаар уур амьсгалын дунджийн орчим байх төлөвтэй.</p>									
Эг, Орхон, Сэлэнгэ Туул голын хөндийгөөр							Шөнө: 8+13 Өдөр: 24+29	Шөнө: 4+9 Өдөр: 17+22	
Нутгийн хойд хэсгээр	Шөнө: -4..+1 Өдөр: 9+14	Шөнө: 4+9 Өдөр: 17+22	Шөнө: -4..+1 Өдөр: 9+14	Шөнө: 4+9 Өдөр: 17+22	Шөнө: -4..+1 Өдөр: 9+14		Шөнө: 5+10 Өдөр: 19+24	Шөнө: -2..+3 Өдөр: 11+16	
Бусад нутгаар								Шөнө: 4+9 Өдөр: 17+22	
<p><b>Хур тунадас:</b> Энэ сард нутгийн өмнөд хэсгээр уур амьсгалын дунджийн орчим бусад нутгаар дунджаас бага зэрэг ахиу хур тунадас орох төлөвтэй.</p>									
Ихэнх нутгаар									
Зарим газраар									
<p><b>Салхи:</b> Бороо орох үеүдэд зарим газраар 9-14м/с, нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёр ба гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр нутгийн өмнөд хэсгээр зарим үед 16-18 м/с хүртэл ширүүсч шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй.</p>									

- хур тунадасгүй
- хур тунадастай
- бороотой

### Хур тунадас


### Агаарын температур



**Хүснэгт I.I.1 Хүн ам, өрх**

Сум	Хүн ам				2018 2017	Эрэгтэй				2018 2017	Эмэгтэй				2018 2017
	2015	2016	2017	2018		2015	2016	2017	2018*		2015	2016	2017	2018	
Баян-Агт	3052	3119	3218	3251	101.0	1550	1583	1632	1645	100.8	1502	1536	1632	1604	100.9
Баяннуур	1868	1818	1861	1827	98.2	983	969	998	976	97.8	885	849	998	850	97.9
Бугат	2182	2241	2277	2198	96.5	1132	1187	1208	1157	95.8	1050	1054	1208	1041	95.8
Булган	12234	12512	12616	12582	99.7	6014	6104	6125	6150	100.4	6220	6408	6125	6422	100.6
Бүрэгхангай	2726	2832	2888	2872	99.4	1388	1459	1482	1469	99.1	1338	1373	1482	1399	99.4
Гурванбулаг	3133	3176	3219	3289	102.2	1617	1644	1660	1686	101.6	1516	1532	1660	1601	101.7
Дашинчилэн	2803	2941	3037	3008	99.0	1431	1492	1540	1523	98.9	1372	1449	1540	1482	99.1
Могод	2685	2701	2729	2711	99.3	1375	1383	1394	1392	99.9	1310	1318	1394	1318	99.9
Орхон	3482	3584	3595	3477	96.7	1865	1911	1913	1856	97.0	1617	1673	1913	1615	97.3
Рашаант	3141	3165	3215	3253	101.2	1583	1602	1618	1641	101.4	1558	1563	1618	1607	101.7
Сайхан	3575	3648	3662	3561	97.2	1816	1854	1871	1799	96.2	1759	1794	1871	1757	96.4
Сэлэнгэ	3207	3306	3332	3343	100.3	1666	1723	1733	1743	100.6	1541	1583	1733	1598	100.7
Тэшиг	3495	3504	3563	3560	99.9	1786	1782	1820	1809	99.4	1709	1722	1820	1751	99.4
Хангал	4548	4611	4705	4660	99.0	2282	2302	2343	2331	99.5	2266	2309	2343	2327	99.6
Хишиг-Өндөр	3154	3156	3158	3152	99.8	1592	1595	1592	1578	99.1	1562	1561	1592	1570	99.4
Хутаг-өндөр	4729	4835	4952	5050	102.0	2432	2487	2546	2573	101.1	2297	2348	2546	2467	101.5
Нийт хүн ам	60014	61149	62027	61794	99.6	30512	31077	31475	31328	99.5	29502	30072	31475	30409	99.7

**Зураг I.I.1 Хүн амын нас хүйсийн суварга 2018 он**



## I.2 ХӨДӨЛМӨР

## Хүснэгт I.2.1 Хөдөлмөр

Үзүүлэлт	2018 I-IV		2019 I-IV		2019 I-IV % 2018 I-IV	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Ажил хайгч иргэн /сарын эцэст/	638	325	1018	501	159.6	154.2
Бүртгэлтэй ажилгүй иргэн /сарын эцэст/	399	220	503	255	126.1	115.9
Ажилд зуучилсан иргэн /эдийн засгийн салбараар/	35	13	85	58	242.9	446.2
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан, агнуур			15	13	-	-
Уул уурхай олборлолт	1		1		0.0	0.0
Боловсруулах үйлдвэр	1		4	2	400.0	0.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалт			1		0.0	0.0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ			2	2	0.0	0.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, холбоо мэдээлэл	1				0.0	0.0
Зочид буудал, байр, сууц болон нитийн хоолны үйлчилгээ	1				0.0	0.0
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1	1	10	5	1000.0	500.0
Боловсрол	4	4	12	10	300.0	250.0
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1		11	10	0.0	0.0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа					0.0	0.0
Бусад	25	8	29	16	116.0	200.0
Ажил хайгч иргэн (насны бүлгээр)	638	325	1018	501	159.6	78.5
15-24	83	45	148	63	178.3	140.0
25-34	204	100	335	167	164.2	167.0
35-44	188	102	280	151	148.9	148.0
45-54	138	71	211	110	152.9	154.9
55-59	21	4	38	7	181.0	175.0
60+	4	3	6	3	150.0	100.0
Ажил хайгч иргэн (боловсролын түвшнээр)	638	325	1018	501	159.6	154.2
Магистр, доктор	1		1	1		
Дипломын болон бакалаврын дээд	91	56	141	81	154.9	144.6
Тусгай мэргэжлийн дунд	27	14	30	19	111.1	135.7
Техникийн болон мэргэжлийн	34	12	47	25	138.2	208.3
Бүрэн дунд	389	203	658	314	169.2	154.7
Суурь	67	29	100	47	149.3	162.1
Бага	20	6	30	9	150.0	150.0
Боловсролгүй	9	5	11	5	122.2	100.0

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

## I.3 НИЙГМИЙН ХАЛАМЖ

## Хүснэгт I.3.2 Нийгмийн халамжийн зарлага, хамрагдсан хүн

Үзүүлэлт	Хүний тоо		Олгосон тэтгэвэр, тэтгэмж, мян. төг		2019 IV 2018 IV
	2018 IV	2019 IV	2018 IV	2019 IV	
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	9916	32885	1184273.6	1533597.6	129.5
Халамжийн тэтгэвэр	1084	995	439068.4	634,454.1	144.5
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	2125	2044	319291.0	435128.9	136.3
Үүнээс:					
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн	707	706	49529.3	67894.0	137.1
Ахмад настныг асарч буй иргэний	871	852	165586.4	233869.3	141.2
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг	334	316	63274.2	86722.9	137.1
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг	187	151	36377.6	40969.3	112.6
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөний	26	19	4523.5	5673.4	125.4
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт	6707	29846	425914.2	464014.6	108.9
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламж	750	410	100588.9	107978.5	107.3
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	97	12105	26469.3	20412.3	77.1
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж	1331	1207	189986.6	166246.8	87.5
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ					
Хүнс тэжээл хөтөлбөр	4,529	16124	108039.0	169377.0	
Төрийн өмнөөс гүйцэтгэсэн ажил үйлчилгээ			830.4		0.0

## Хүснэгт I.3.3 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага

Үзүүлэлтүүд	2015 I-IV	2016 I-IV	2017 I-IV	2018 I-IV	2019 I-IV	2019 I-IV 2018 I-IV
<b>Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг</b>	<b>3378.3</b>	<b>3869.5</b>	<b>3798.6</b>	<b>3325.5</b>	<b>4263.9</b>	<b>128.2</b>
Үүнээс:						
Тэтгэврийн даатгалын сан	2179.4	2377.1	2218.4	2715.9	3364.9	123.9
Тэтгэмжийн даатгалын сан	250.2	266.7	297.7	338.2	562.8	166.4
Эрүүл мэндийн даатгалын сан	730.9	987.1	1054.5			
ҮОМШӨ*-ний даатгалын сан	160	174.6	161	195	240.3	123.2
Ажилгүйдлийн даатгалын сан	57.8	64	67	76.4	95.9	125.5
<b>Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг</b>	<b>9451.1</b>	<b>9938</b>	<b>11065.4</b>	<b>11517.5</b>	<b>19919.7</b>	<b>173.0</b>
Үүнээс:						
Тэтгэврийн даатгалын сан	8172.6	8653.6	9709.7	10882.6	19256.2	176.9
